



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/190/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@auditgov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn Аудитор Б.Отгонцэцэг Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ОЧИРБАТ ТАНАА

2025.02.24 № 07/635
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу, хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа харьцуулалтын аргаас зайлсхийж 100,225.0 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулсан;
- Дотоод албан томилолтоор ажилласан 37 хүнд 5,560.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон;
- Албан хаагчдад урамшуулал олгохдоо 10,820.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй;
- Харьяа байгууллагуудад хуваарилсан 99,268.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Ажилчдад 6,429.7 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү тооцож олгосон;
- Жилийн эцэст 33,644.5 мянган төгрөгийн авлага 13,750.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд

зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын “Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2024 оны 62 дугаар тогтоолын дагуу нөөц сангаас алслагдсан сумдын эрүүл мэндийн төвд туулах чадвар сайтай 60 ширхэг автомашиныг 9,600,000.0 мянган төгрөгөөр бэлтгэж, 19 аймгийн 60 сумын эрүүл мэндийн төвүүдэд хуваарилсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн салбарын 7 хоног арга хэмжээний хүрээнд “Эмч нарын VII их хурал”, Багийн эмч нарын зөвлөгөөнийг зохион байгуулж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас санхүүжүүлж 94,688.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоолоор тус яамны бүтцийг 7 газар, 11 хэлтэстэй, орон тоог 114 байхаар баталсан байна.

Халдварт бус өвчний эрт илрүүлэх үйл ажиллагааны хүрээнд сургуулийн 277 эмч, нийгмийн ажилтан, Өрхийн эрүүл мэндийн төвийн 280 эмч, сувилагч, шүдний 256 эмчийг сургалтанд хамруулсны үр дүнд Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр ангийн 27,070 сурагчдийг нүд, шүд, зүрхний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,220,567,440.03	555,371,034.32
33	АВЛАГА	503,747,536.74	186,023,746.81
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	2,346,449.00	2,346,449.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	37,769,168.94	-
33500	Бусад авлага	463,631,918.80	183,677,297.81
33510	Байгууллагаас авах авлага	463,631,918.80	183,677,297.81
34	УРЬДЧИЛГАА	55,387,706.30	132,252,192.50
34600	Урьдчилж төлсөн зардал	55,387,706.30	132,252,192.50
35	БАРАА МАТЕРИАЛ	564,367,118.98	237,095,095.01
35100	Түүхий эд материал	288,101,468.18	-
35110	Тусгай зориулалттай материал	288,101,468.18	-
35400	Хангамжийн материал	276,265,650.80	237,095,095.01
35410	Бичиг хэргийн материал	205,975.00	4,015,885.00
35420	Аж ахуйн материал	81,304,426.00	58,434,350.00
35430	Сэлбэг хэрэгсэл	28,119,100.00	27,874,400.00
35440	Түлш, шатах тослох материал	7,629,305.00	3,346,014.71
35470	Бусад хангамжийн материал	159,006,844.80	143,424,445.30
36	НӨӨЦИЙН БАРАА	97,065,078.01	-
36800	Бусад эргэлтийн бус хөрөнгө	97,065,078.01	-
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,504,319,066.65	6,405,964,145.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,504,319,066.65	6,405,964,145.38
39200	Биет хөрөнгө	4,518,456,256.74	3,881,846,952.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,998,322,269.55	2,998,322,269.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	887,221,385.80	1,064,316,204.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	735,937,005.00	693,937,005.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	345,520,892.18	357,734,592.74
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	4,563,382,009.15	4,147,809,379.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	2,713,527,344.55	2,759,387,076.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	502,306,915.64	432,747,154.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	358,212,042.75	226,955,469.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	40,044,381.47	39,384,381.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	17,054,658.79	21,959,894.89
39300	Биет бус хөрөнгө	3,985,862,809.91	2,524,117,192.77
39301	Программ хангамж	7,134,752,787.49	7,125,432,787.49
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,245,479,517.58	4,697,905,134.72
39303	Бусад биет бус хөрөнгө	96,589,540.00	96,589,540.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,724,886,506.68	6,961,335,179.70
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,556,253.90	3,363,487,441.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,556,253.90	3,363,487,441.06
41300	Өглөг	43,556,253.90	3,363,487,441.06
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	213,608.06	1,487,441.06
41360	Бусад өглөг	43,342,645.84	3,362,000,000.00
41361	Байгууллагад өгөх өглөг	40,472,645.84	3,360,000,000.00
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	2,870,000.00	2,000,000.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	9,681,330,252.78	3,597,847,738.64
51	Засгийн газрын хувь оролцоо	2,742,600,541.40	2,742,600,541.40
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,742,600,541.40	2,742,600,541.40
51200	Хуримтлагдсан үр дүн	4,703,266,990.17	(1,380,215,523.97)
51210	Өмнөх үеийн үр дүн	4,703,266,990.17	4,330,196,848.01
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(5,710,412,371.98)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,235,462,721.21	2,235,462,721.21

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,724,886,506.68	6,961,335,179.70
------	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	18,118,443,721.13	20,251,873,831.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,034,125,297.65	3,457,712,621.51
120	Нийтлэг татварын бус орлого	9,034,125,297.65	3,457,712,621.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,034,125,297.65	3,457,712,621.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,519,191.00	4,545,497.94
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,597,468,377.00	566,535,201.52
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,411,137,729.65	2,886,631,922.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,084,318,423.48	16,794,161,210.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,295,859,137.73	9,302,652,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,295,859,137.73	9,302,652,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,788,459,285.75	7,491,508,410.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,009,838,155.75	1,151,055,430.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	768,445,080.00	6,340,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,176,050.00	452,980.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,761,737,916.43	12,968,481,478.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,761,737,916.43	12,968,481,478.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,729,454,850.69	10,948,112,902.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,464,317,551.36	4,048,064,566.00
210101	Үндсэн цалин	2,046,156,837.36	2,304,368,306.00
210102	Нэмэгдэл	762,179,675.00	969,534,860.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	392,864,000.00	423,072,000.00
210104	Урамшуулал	242,502,939.00	351,089,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,614,100.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	445,811,401.72	510,701,811.14
210201	Тэтгэврийн даатгал	305,335,009.51	348,042,083.43
210202	Тэтгэмжийн даатгал	39,510,518.12	40,946,127.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,090,076.36	21,130,242.04
210204	Ажилгүйдлийн даатгал	6,698,603.36	20,116,664.47
210205	Эрүүл мэндийн даатгал	67,177,194.37	80,466,693.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,397,800.00	106,783,600.00
210301	Гэрэл, цахилгаан	33,962,600.00	51,975,100.00
210302	Түлш, халаалт	26,917,900.00	40,448,300.00
210303	Цэвэр, бохир ус	10,236,500.00	14,360,200.00
210304	Байрны түрээс	25,280,800.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	179,736,749.53	170,365,991.07
210401	Бичиг хэрэг	36,225,600.00	38,289,203.34
210402	Тээвэр, шатахуун	43,126,122.00	65,334,331.29

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
хураангуй тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,523,792.31	37,149,552.44
210404	Ном, хэвлэл	38,250,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,839,286.22	10,316,662.00
210408	Бараа материал акталсны зардал	6,771,949.00	19,276,242.00
2105	Норматив зардал	120,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,426,880.00	11,211,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,216,800.00	5,812,900.00
210604	Урсгал засвар	3,210,080.00	5,398,500.00
2107	Томилолт, зочны зардал	247,007,343.60	238,309,033.00
210701	Гадаад албан томилолт	20,070,898.00	67,546,080.00
210702	Дотоод албан томилолт	226,936,445.60	170,762,953.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,210,650,181.40	929,465,983.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,192,894,013.40	879,056,953.02
210803	Даатгалын үйлчилгээ	3,675,700.00	2,128,807.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,818.00	551,301.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	91,000.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,394,170.00	24,552,791.94
210807	Газрын төлбөр	877,300.00	2,378,040.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	145,600.00	30,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,291,580.00	20,646,090.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,073,986,943.08	4,933,010,517.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,256,713,347.10	1,840,823,319.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	362,384,416.10	372,624,462.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,454,889,179.88	2,719,562,735.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,032,283,065.74	2,020,368,576.45
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	65,499,697.64	78,591,441.20
213102	Засгийн газрын урсгал шилжүүлэг	65,499,697.64	78,591,441.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,711,737,459.28	1,730,026,505.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,596,134,440.28	1,683,072,505.61
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	88,803,119.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,799,900.00	46,954,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	95,614,758.32	211,297,649.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,614,758.32	211,297,649.64
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	159,431,150.50	452,980.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	159,431,150.50	452,980.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	6,356,705,804.70	7,283,392,352.94
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,140,503,828.52	12,993,804,724.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	18,066,253,828.24	12,993,804,724.92
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(11,783,798,023.82)	(5,710,412,371.98)

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,270,297,719.57	16,843,053,639.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,241,311.00	11,273,260.94
120	Нийтлэг татварын бус орлого	5,241,311.00	11,273,260.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,091,311.00	11,273,260.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,091,311.00	11,273,260.94
120009	Бусад орлого	150,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,265,056,408.57	16,831,780,378.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,295,859,137.73	9,302,652,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,295,859,137.73	9,302,652,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,969,197,270.84	7,529,127,578.94
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,110,873,668.25	1,151,055,430.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	768,445,080.00	6,340,000,000.00
131104	Нэмэлт санхүүжилт	79,702,472.59	37,619,168.94
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,176,050.00	452,980.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,196,697,869.57	16,728,523,834.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,196,697,869.57	16,728,523,834.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,120,055,634.89	14,708,505,258.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,498,046,045.86	4,116,334,200.62
210101	Үндсэн цалин	2,041,736,985.41	2,292,787,908.62
210102	Нэмэгдэл	798,271,022.74	1,022,256,334.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	395,402,374.51	423,219,396.00
210104	Урамшуулал	242,171,563.20	378,070,562.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,464,100.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	452,587,600.00	518,290,187.05
210201	Тэтгэврийн даатгал	307,759,600.00	342,870,487.69
210202	Тэтгэмжийн даатгал	36,207,000.00	43,773,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,965,600.00	22,210,899.36
210204	Ажилгүйдлийн даатгал	7,241,400.00	21,887,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	72,414,000.00	87,547,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,504,700.00	106,873,200.00
210301	Гэрэл, цахилгаан	40,755,200.00	51,975,100.00
210302	Түлш, халаалт	30,763,300.00	39,232,400.00
210303	Цэвэр, бохир ус	12,283,900.00	15,665,700.00
210304	Байрны түрээс	15,702,300.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	144,908,858.53	114,160,097.78
210401	Бичиг хэрэг	26,324,570.00	37,435,323.34
210402	Тээвэр, шатахуун	18,149,200.00	25,406,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,523,792.31	37,179,152.44
210404	Ном, хэвлэл	38,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,911,296.22	14,138,722.00
2105	Норматив зардал	709,400.00	1,962,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	709,400.00	1,962,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,019,880.00	18,215,698.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,679,800.00	12,817,198.00

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210604	Урсгал засвар	4,340,080.00	5,398,500.00
2107	Томилолт, зочны зардал	217,022,134.60	242,089,033.00
210701	Гадаад албан томилолт	-	82,614,800.00
210702	Дотоод албан томилолт	217,022,134.60	159,474,233.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,012,088,146.50	1,031,463,686.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	986,559,878.50	981,253,354.50
210803	Даатгалын үйлчилгээ	3,675,700.00	4,905,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,818.00	490,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	91,000.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,985,770.00	24,524,999.94
210807	Газрын төлбөр	877,300.00	938,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	145,600.00	30,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,472,080.00	19,199,132.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,681,168,869.40	8,559,117,155.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,290,002,402.00	8,175,834,907.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	391,166,467.40	383,282,248.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,076,642,234.68	2,020,018,576.45
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	65,499,697.64	78,591,441.20
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	65,499,697.64	78,591,441.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,718,327,459.28	1,729,676,505.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,596,134,440.28	1,683,072,505.61
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	88,803,119.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,389,900.00	46,604,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	95,764,758.32	211,297,649.64
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,764,758.32	211,297,649.64
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	197,050,319.44	452,980.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,050,319.44	452,980.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	73,599,850.00	114,529,805.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	79,739,850.00	114,529,805.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	79,739,850.00	114,529,805.00
2200	Дотоод эх үүсвэрээр	79,739,850.00	114,529,805.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	62,813,850.00	114,529,805.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(79,739,850.00)	(114,529,805.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,140,000.00)	-
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,140,000.00	-
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	2,742,600,541.40	2,235,462,721.21	16,487,065,013.99	21,465,128,276.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,742,600,541.40	2,235,462,721.21	16,487,065,013.99	21,465,128,276.60
Тайлангийн үеийн үр дүн	-	-	(11,783,798,023.82)	(11,783,798,023.82)
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	2,742,600,541.40	2,235,462,721.21	4,703,266,990.17	9,681,330,252.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(373,070,142.16)	(371,902,859.16)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,742,600,541.40	2,235,462,721.21	4,330,196,848.01	9,308,260,110.62
Тайлангийн үеийн үр дүн	-	-	(5,710,412,371.98)	(5,710,412,371.98)
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	2,742,600,541.40	2,235,462,721.21	(1,380,215,523.97)	3,597,847,738.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,311,652,800.00	9,102,628,411.30	209,024,388.70	97.8
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	9,311,652,800.00	9,102,628,411.30	209,024,388.70	97.8
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	7,346,014,600.00	7,294,360,464.49	51,654,135.51	99.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,679,071,500.00	2,659,736,076.82	19,335,423.18	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	4,119,768,900.00	4,116,334,200.62	3,434,699.38	99.9
210101	Үндсэн цалин	2,529,717,900.00	2,292,787,908.62	236,929,991.38	90.6
210102	Нэмэгдэл цалин	838,973,300.00	1,022,256,334.00	(183,283,034.0)	121.9
210103	Унаа хоолны нэмэгдэл	405,957,400.00	423,219,396.00	(17,261,996.00)	104.3
210104	Урамшуулал	345,120,300.00	378,070,562.00	(32,950,262.00)	109.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	547,174,200.00	518,290,187.05	28,884,012.95	94.7
210201	Тэтгэврийн даатгал	372,078,500.00	342,870,487.69	29,208,012.31	92.2
210202	Тэтгэмжийн даатгал	43,773,900.00	43,773,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,886,900.00	22,210,899.36	(323,999.36)	101.5
210204	Ажилгүйдлийн даатгал	21,887,000.00	21,887,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	87,547,900.00	87,547,900.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,873,200.00	106,873,200.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	51,975,100.00	51,975,100.00	-	100.0
210302	Түлш, халаалт	39,232,400.00	39,232,400.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	15,665,700.00	15,665,700.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	116,639,900.00	116,511,497.78	128,402.22	99.9
210401	Бичиг хэрэг	39,240,000.00	39,235,323.34	4,676.66	100.0
210402	Тээвэр, шатахуун	25,406,900.00	25,406,900.00	-	100.0

**Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
хураангуй тайлан**

210403	Шуудан,холбоо, интернэтийн төлбөр	37,278,000.00	37,179,152.44	98,847.56	99.7
210406	БҮТЭЗҮЙЛС	14,715,000.00	14,690,122.00	24,878.00	99.8
2105	Нормативд зардал	1,962,000.00	1,962,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,962,000.00	1,962,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,050,000.00	48,850,403.00	199,597.00	99.6
210601	Багаж,техник хэрэгсэл	39,240,000.00	39,040,403.00	199,597.00	99.5
210604	Урсгал засвар	9,810,000.00	9,810,000.00	-	100
2107	Томилолт, зочны зардал	249,970,500.00	242,089,033.00	7,881,467.00	96.9
210701	Гадаад албан томилолт	82,614,800.00	82,614,800.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	167,355,700.00	159,474,233.00	7,881,467.00	95.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,042,567,100.00	1,031,463,686.44	11,103,413.56	98.9
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	991,653,200.00	981,253,354.50	10,399,845.50	99.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,905,000.00	4,905,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	490,500.00	490,500.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	196,200.00	122,000.00	74,200.00	62.2
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	24,525,000.00	24,524,999.94	0.06	100.0
210807	Газрын төлбөр	981,000.00	938,700.00	42,300.00	95.7
210808	Банк,санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	196,200.00	30,000.00	166,200.00	15.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	19,620,000.00	19,199,132.00	420,868.00	97.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,112,008,800.00	1,111,986,256.60	22,543.40	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	958,179,800.00	958,157,257.00	22,543.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	153,829,000.00	153,828,999.60	0.4	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,965,638,200.00	1,808,267,946.81	157,370,253.19	92.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	81,310,200.00	78,591,441.20	2,718,758.80	96.7
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	81,310,200.00	78,591,441.20	2,718,758.80	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,884,328,000.00	1,729,676,505.61	154,651,494.39	91.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж,урамшуулал	1,837,500,000.00	1,683,072,505.61	154,427,494.39	91.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,828,000.00	46,604,000.00	224,000.00	99.5
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,311,652,800.00	9,102,628,411.30	209,024,388.70	97.8
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	9,000,000.00	11,273,260.94	(2,273,260.94)	125.3
1200042_1	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	9,000,000.00	11,273,260.94	(2,273,260.94)	125.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,302,652,800.00	9,091,355,150.36	211,297,649.64	97.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	9,302,652,800.00	9,091,355,150.36	211,297,649.64	97.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	229	229	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	114	114	-	100.0
620001	Удирдах ажилтан	8	8	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	106	106	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,529,127,578.94
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	7,529,127,578.94
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	7,528,674,598.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,528,674,598.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,528,674,598.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,299,221,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	229,453,248.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	452,980.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	452,980.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	452,980.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,529,127,578.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	7,529,127,578.94
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,151,055,430.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,340,000,000.00
131104	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	37,619,168.94
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	452,980.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 2,628,720.8 мянган төгрөгийн 8 алдаа¹ илрүүлж, аудитын явцад 2,623,182.3 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 5,538.5 мянган төгрөгийн 1 алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайланг бараа материалын тодруулгын тайлангаас 1,816,106.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	1,816,106.8			1	1,816,106.8	1	1,816,106.8				
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын зардлыг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэж буруу тайлагнасан.	1	157.1			1	157.1	1	157.1				
Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас орж ирсэн санхүүжилтийг 5,308.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	5,308.2			1	5,308.2	1	5,308.2				
Өмнөх онд олгосон шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсаны тэтгэмжийн зардал 118,092.8 мянган төгрөг, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 41,637.7 мянган төгрөг нийт 159,730.5 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй өмнөх үеийн үр дүнд хааж буруу бичилт хийсэн.	1	159,730.5			1	159,730.5	1	159,730.5				
Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд ТӨБЗГ-ын шийдвэрээр элэгдлээ байгуулж дууссан хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож орлогод авахдаа дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэж буруу тайлагнасан.	1	565,855.2			1	565,855.2	1	565,855.2				
Бараа материалын тодруулгын тайланд 400.0 мянган төгрөгийн акталсан бараа материалыг дутуу тусгасан.	1	400.0			1	400.0	1	400.0				
Бараа материалын тодруулгын тайланд үнэ төлбөргүй шилжүүлсэн 75,624.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын	1	75,624.5			1	75,624.5	1	75,624.5				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

материалыг худалдан зарцуулснаар тайлагнасан.											
Бараа материалын дансанд бүртгэлтэй 129 ширхэг улсын байцаагчийн тэмдэг, 4 ширхэг байцаагчийн тамга, 3 ширхэг хяналтын улсын байцаагчийн тэмдэг зэрэг нийт 5,538.5 мянган төгрөгийн тамга тэмдгийг тараасан боловч эд хариуцагчийн картад бүртгээгүй, сэлбэг хэрэгсэл дансанд буруу бүртгэсэн.	1	5,538.5			1	5,538.5			1	5,538.5	
Дүн	8	2,628,720.8			8	2,628,720.8	7	2,623,182.3	1	5,538.5	

3.2 Аудитаар нийт 3,736,139.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 650,654.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 16,380.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 2,859,817.9 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага, 209,287.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо/дүн	Тоо	Дүн
Байгууллагын үйл ажиллагаанд 1-12 дугаар сард зарцуулсан нийт 46,455.2 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодож, тайланг гаргаагүй, жолоочийн замын хуудсыг бүрэн хөтөлж, гарын үсгээр баталгаажгаагүй.	1	46,455.2			1	46,455.2						
Гэрийн дээвэр, туурга 2,420.0 мянган төгрөгөөр худалдаж аваад орлогод аваагүй, өмнөх онуудад бэлтгэсэн байгууллагын 5 ханатай гэрийг орлогод аваагүйгээс данс бүртгэлд байхгүй	1	2,420.0					1	2,420.0				

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Глобал сангийн ДОХ, Сүрьеэгийн төслөөр 27 нэр төрлийн 2,182,953.8 мянган төгрөг, НҮБ-ийн хүүхдийн сангаас 10 нэр төрлийн 676,864.1 мянган төгрөг, нийт 37 нэр төрлийн 2,859,817.9 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй нийлүүлснийг нүдээр үзэж хүлээж аваагүй, ТНБД-ын тушаалыг үндэслэн орлого авч, хуваарийн дагуу зарлагдаж байгаагаас хөрөнгө дутагдах, үр ашиггүй хөрөнгийн нөөц бий болох эрсдэлтэй байна.	1	2,859,817.9							1	2,859,817.9		
Жилийн эцэст ЭМС-ын болон ТНБД-ын тушаалаар салбарын байгууллагуудад шилжүүлсэн 99,268.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээлцсэн акт үйлдээгүй, тооцоо нийлээгүй байна.	1	99,268.5			1	99,268.5						
Тайлант онд дотоод албан томилолтоор ажилласан нийт 37 хүнд 5,560.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.	1	5,560.0	1	5,560.0								
Эрүүл мэндийн салбарт цахим шилжилт хийх ажлыг эрчимтэй явуулсан албан тушаалтнуудад 102,200.0 мянган төгрөг, Төрийн албаны зөвлөлийн эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн гишүүдэд 6,000 мянган төгрөг, нийт 108,200.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татвар суутгаж аваагүй байна.	1	10,820.0	1	10,820.0								
ТНБД-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/138 дугаар тушаалаар ажилчдад нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан цагаас хэтрүүлж нийт 6,429.7 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү тооцож олгосон байна.	1	6,429.7			1	6,429.7						
Жилийн эцэст 33,644.5 мянган төгрөгийн авлага 13,750.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Үүнээс ажиллагсдаас авах 2,346.5 мянган	1	47,394.5			1	47,394.5						

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдлийн барагдуулах талаар арга хэмжээ аваагүй.												
Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс цалингийн нөхөн олговорт 131,385.8 мянган төгрөгийг олгож, төрийн албаны зөвлөлөөс авах авлагаар бүртгэсэн ч тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Мөн өмнөх онд төсвөөс 118,092.9 мянган төгрөгийн нөхөн олговор олгосонд Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.	1	131,385.8			1	131,385.8						
ТНБД-ын 2024 оны А/145 дугаар тушаалаар шинжээчийн ажлын хөлс 8,290.0 мянган төгрөг, А/143 дугаар тушаалаар Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Эрүүл мэндийн яамны салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулал 6,000.0 мянган төгрөг, нийт 14,290.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгож зардлын ангилал зөрчсөн.	1	14,290.0			1	14,290.0						
Шуудан холбоо интернэтийн зардлаас 29.6 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 662.0 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардлаас 504.0 мянган төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 68,478.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 43,753.3 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 9,682.6 мянган төгрөг, нийт 123,110.3 мянган төгрөгийг зардлын ангилал зөрсөн, 79,020.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,074.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 82,094.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	1	205,205.5			1	205,205.5						

Эрүүл мэндийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тайлант онд эмч нарын 7 дугаар их хурал, багийн эмч нарын зөвлөгөөн, удирдах албан тушаалтны зөвлөгөөн зэрэг арга хэмжээг зохион байгуулахад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй заал түрээслэх, дэвтэр бал, энгэрийн тэмдэг, урлагийн тоглолт зэрэг бараа,ажил үйлчилгээг худалдан авахад нийт 206,867.5 мянган төгрөгийг төсвөөс үрэлгэн зарцуулсан.	1	206,867.5					1	206,867.5				
"Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурагчдад хараа шалгах эрт илрүүлгийн үзлэг хийх, сургуулийн эмч, нийгмийн ажилтан нарыг чадавхжуулах сургалт" зохион байгуулахдаа ижил төрлийн 49,900.0 мянган төгрөгийн үйлчилгээг нэг аж ахуйн нэгжтэй 3 хувааж шууд гэрээ байгуулсан, мөн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, хувь хүний хөгжил" сургалтыг зохион байгуулахдаа ажил гүйцэтгэх 50,325.0 мянган төгрөгийн шууд гэрээг тус тус байгуулж, харьцуулалтын аргаас зайлсхийсэн.	1	100,225.0			1	100,225.0						
Дүн	13	3,736,139.6	2	16,380.0	8	650,654.20	2	209,287.5	1	2,859,817.9	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 78,836.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Эмэгтэйчүүдийн баярыг тэмдэглэхэд төсвөөс 8,240.0 мянган төгрөг, бэлэг дурсгалд 69,500.0 мянган төгрөг, поло бутфолок 1,096.0 мянган төгрөгөөр худалдан авч төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн	1	78,836.0	1	78,836.0		
Дүн	1.00	78,836.0	1.00	78,836.0		